


ОРЧУУЛАГЧ АРТЫН БЯМБАНОРОВЫН БҮТЭЭЛИЙН ТУХАЙД

Б.Энхбаяр¹⁴⁷

ABSTRACT: *In the paper I try to briefly focus on translator's main works, specific features and his translation skills as well as some biographical backgrounds, as I am aware of this, as his daughter. As one of the well known translators and editors in the XX century, Byambanorov. A devoted himself mainly to the translation in the field of theory, politics, and economy. However, his translation work was not limited only by above mentioned fields, a number of books related to culture and knowledge as well as literary works dedicated to children were translated by him.*

Түлхүүр үг: орчуулга, орчуулагч, нийгэм, улс төр, эдийн засаг, уран зохиол



Алаг адуу овогт Артын Бямбаноров нь улс төр, уран зохиолын номын орчуулагч, редактор, нийтлэлч, багш, эдийн засагч хүн байлаа. Энэ хүн бол миний хувьд онцгой хүн, миний аав юм.

Энэхүү өгүүлэлд аавыгаа 20-р зууны үеийн орчуулагч сэхээтнүүдийн төлөөлөл болохын хувьд орчуулгынх нь төрөл, бүтээл, онцлог болоод орчуулагчийнх нь чадвар талаас нь авч үзэхийн зэрэгцээ ажил амьдралынх нь замналаас товч харуулах зорилго тавьлаа.

1. Ажил амьдралын замналаас: Орчуулагч А.Бямбаноров 1924 онд Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт Галуутайн эхэнд Урт булагт гэдэг газар малчин ард Артын тав дахь хүү болон төржээ. 11 нас хүртэл эцэг эхийн гар дээр хүмүүжин мал маллаж, гэр орны ойр зуурын ажилд тусалж байгаад 1935-1938 онд сумынхаа бага сургуульд, 1938-1941 онд Зөвлөлт Буриадын нийслэл Улаан-Үдийн рабфак-т (рабочий факультет) суралцаж байсан нь тухайн үеийн сургууль соёлын мөр хөөсөн манай ууган сэхээтнүүдийн л жишиг байжээ. Дэлхийн 2-р дайн эхэлснээр монгол хүүхдүүдийг нутагт нь буцаасан тул сургуулиа дүүргэж чадаагүй байна. 1941-1942 онд Багшийн сургуульд орж үргэлжлүүлэн суралцжээ. Тэрээр 1950-1953 онд Намын шинэ хүчний дээд

¹⁴⁷ МУИС, ШУС, ХУС-ын ГХТ-ийн багш, доктор /Ph.D/

сургууль, 1963-1965 онд Эдийн засгийн дээд сургуулийн 3-р курсэд шууд элсэн суралцаж төгссөн төлөвлөгч-эдийн засагч мэргэжилтэй хүн байлаа.

А.Бямбаноров улсад нийтдээ 47 жил ажиллажээ. Тухайлбал, 1942-1950 онуудад Завхан аймгийн төвийн дунд сургуульд 17 настайдаа багшилж эхэлснээр хожим нь Завханмандал, Дөрвөлжин, Түдэвтэй, Улаагчин, Их Уул, Сонгино, Нөмрөг зэрэг сумын сургуулиудад хичээлийн эрхлэгч, захирлын алба хашиж байлаа. 1953-1955 онд МАХН-ын Төв Хороонд лектор буюу суртал ухуулагч, 1955-1957 онд МУИС-ийн намын хорооны дарга, Улсын Хэвлэх үйлдвэрт намын хорооны дарга, 1957-1960 онд Улаанбаатар хотын МАХН-ын Хорооны дэргэдэх марксизм-ленинизмын оройн дээд курс болон Намын дээд сургуульд багш, 1960-1975 онд Улсын Хэвлэх үйлдвэрийн дэргэдэх Хэвлэлийн Нэгдсэн Редакцид 15 жилийн турш улс төрийн номын ахлах редактор зэрэг ажил хашиж байгаад 1975 оны 3 сард тухайн үеийн МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр ЗХУ-ын Прогресс хэвлэлийн газар орчуулагч редактороор томилогдон 1980 он хүртэл 5 жил үр бүтээлтэй ажилласан байна. 1980 оны 9 сарын 14-нд эх орондоо эргэн ирж тухайн үеийн МАХН-ын Төв Хорооны харьяа Намын Түүхийн Институтэд орчуулагч-редактороор ажиллаж байгаад 1982 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан билээ.

Аливаа хүн ажил сургуульд ороход албан ёсны товч намтар бичиж ярилцлага өгдөг, тухайн сургууль, албан байгууллага ч мэргэжил, боловсрол, ажлын туршлагыг нь харгалзан сонгож авдаг нь нэгэнтээ дэлхий нийтийн жишиг. Хуучин хэмээн нэрийддэг тогтолцооны үед ажилтан сонгохдоо нам, фракц буюу арын хаалгаар бус, ажлын туршлага, мэргэжил боловсрол хийгээд хариуцлага, чадвар зэргийг нь харгалзаж удирдах дээд баайгууллагын шийдвэрээр буюу нарийн ”цензур”-аар шалгаруулдаг байсан нь өнөө үгүйлэгдэж байгаа билээ. А.Бямбаноровын намтар түүхийг нэхэн үзвээс тухайн үедээ хариуцлагатай албан тушаал хашихын зэрэгцээ улсаа төлөөлөн гадны оронд тодорхой хугацаагаар амжилттай ажиллаж байсан нь нэгийг өгүүлнэ.

Нэгэнтээ нэрт дуун хөрвүүлэгч, Соёлын Гавьяат Зүтгэлтэн Г.Аким: “...Цаг үедээ улс төр онолын мэдлэгээр толгой цохих сэхээтний нэг гэгдэж, үзэл суртал хэвлэлийн чухал алба хашиж явсан А.Бямбаноров багштан...”¹⁴⁸ хэмээн өгүүлсэн нь санамсаргүй зүйл бус хэмээн үзэж байна.

Орчуулагч А.Бямбаноров улсад зүтгэн ажилласан хугацааныхаа ихэнхийг буюу 37 жилийг дан ганц хэвлэл номын ажилд зориулж 50 гаруй том жижиг ном орчуулан, 100 гаруй номын орчуулгыг хянан засварласны зэрэгцээ нийгэм, улс төр соёлын цаг үеийн асуудлаар өдий төдий өгүүлэл шүүмж нийтлэл бичиж төвийн хэвлэлд нийтлүүлсэн байна. Эзэмшсэн мэргэжил боловсролынх нь үүднээс авч үзвэл “мэргэжлийн бус” орчуулагч нь тодорхой. Гэвч алив хүний

¹⁴⁸ Г.Аким “Дуун хөрвүүлэгчийн тавилан” хэмээх нэрт орчуулагч Г.Амар агсны 80 насны ойд зориулан бичсэн өгүүллээс авав.

мэдлэг чадварыг дан ганц дипломоор хэмжих нь учир дутагдалтайг миний бие олон жил боловсрол шинжлэх ухааны байгууллагад ажиллаж багшилсны хувьд сайн мэдэрч ойлгодог билээ.

МАХН-ын Төв Хорооны томилолтоор ихэвчлэн намын хорооны дарга гэсэн алба хашиж байгаад орчуулагч-редактор хэмээх өөр ажил албатай болсон нь ч тодорхой учир шалтгаантай. Тэртээ 1950-иад оны дундуур сэхээтний төөрөгдөл гэгчээр улс эх орноо гэсэн сэтгэл зүрхтэй олон арван сэхээтэн үнэн үг хэлснийхээ төлөө буруудан хэлмэгдэж байсан билээ. Тэр үед МУИС-д багшилж байсан, хожмын нэртэй эрдэмтэд, зохиолчид нийгэм эдийн засгийн дутагдалтай, болохгүй байгаа зүйлсийг ил тод хэлж буруудахад сургуулийн намын хорооны нарийн бичгийн дарга байсан А.Бямбаноров багш нараа асуудалд бодитой хандаж үнэн үг хэлсэн хэмээн хамгаалснаар МАХН-ын Төв Хороон дээр тухайн үед МУИС-д багшилж байсан их эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн хамт дуудагдан хурлаар орж “... намын найдварыг хугалсан үл бүтэх этгээд”¹⁴⁹ хэмээн цоллуулж буруудан ажлаасаа халагдсан юм. Сэхээтний төөрөгдлөөр буруудсан, ажил албаа алдсан гэж огт үздэггүй, гоморхдоггүй хүн байсан бөгөөд орчуулгын ажилдаа үнэнхүү дуртай тэрээр бидэнд “Сэхээтний төөрөгдөл” гэгчид оролцсон хэргээр ажлаасаа авахуулсан маань харин ч намайг номтой нөхөрлүүлж энэ сайхан ажилтай зууралдуулсан юм даа гэж дурсдаг байлаа.

2. Орчуулгын төрөл:

Орчуулагч А.Бямбаноровын орчуулгын төрөл чиглэлийг ерөнхийд нь:

- улс төр, нийгэм, эдийн засаг
- танин мэдэхүй, соёл
- уран зохиол, хүүхдийн ном зохиол, үлгэр гэж 3 ангилж болно.

Хэвлэлийн нэгдсэн редакцид улс төрийн номын редакц болон эдийн засгийн редакцийг олон жил ахлан ажиллаж байсны хувьд нийгэм, улс төр, эдийн засгийн төрлийн ном зохиол түлхүү орчуулж редакторлосон байдаг.

Энд редакторлосон бус, зөвхөн өөрийн нь орчуулсан томоохон бүтээлийн заримаас дурдвал: В.Ардаматскийн “Чадах бүхнээ хийлээ”, С.Буденныйн “Туулсан зам” 1, 2-р боть, Л.Делюсиний “Хятад дахь соёлын хувьсгал”, Т.Живковын “Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг”, Хо Ши Миний “Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг”, Л.Брежневийн “Лениний зааснаар” 1, 2-р ботиуд, В.И.Лениний “Эдийн засгийн сургааль ба орчин үе”, Бурдуковын “Ахан дүү ард түмэн”, И.Голосовскийн “Итгэмээр санагдана”, “Эх орны дайны түүх”, О.В.Боровьевагийн “Марксын охид”, Е.С.Матвеевагийн “БНМАУ-д хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчилсөн нь”, М.Сусловын “Пролетарийн интернационализм ба ажилчин анги”, “Хөгжингүй социалист нийгэм: мөн чанар,

¹⁴⁹ Л.Зоригт. “Үнэнд үнэнч байсан уу” өгүүлэл, Улаан-Од сонин, 1989-10-25, № 85.

хөгжлийн шалгуур”, “Маркс судлалын гуйланчлал”, Варнайн “Маоизм олон улсын коммунист хөдөлгөөнийг задраан бутрааж байгаа нь”, В.В.Кузьмины “Хятадын талаарх Америкийн империализмын стратеги”, “ЭЗХТЗ-ийн хамтын нөхөрлөлийн орнууд (толь бичиг), О.Б.Борисов нарын “Зөвлөлт-Хятадын харилцаа”, Ж.Нэругийн “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” зэрэг олон ном орчуулжээ. Мөн К.Маркс, Ф.Энгельсийн зарим боть болон В.И.Лениний 9,12-р ботиудаас орчуулалцсан байна.

Дээрх улс төр, эдийн засгийн холбогдолтой ном зохиолууд нь тухайн цаг үеийн үзэл суртлыг ямар нэг хэмжээгээр агуулсан ч түүхийн нэгээхэн хэсэг үеийг харуулсан баримт бүхий судалгааны болон онолын шинжтэй зохиолууд байгаа нь орчуулагчийн чадвар хариуцлагатай холбоотой. Үүний сацуу намын даалгавраар нам, улсын их бага болоод бүгд хурлуудын материалууд, төрийн зүтгэлтнүүдийн илтгэл, хэлсэн үг өгүүллээс ихээхэн хэмжээгээр орчуулж байсан нь ч орчуулагч А.Бямбаноровын орчуулах эрдэм, чадвар чансааг төр засгаас хэрхэн үнэлж байсны баталгаа болно.

Орчуулгын энэ төрлийн бүтээлүүдээс нь Энэтхэгийн анхны ерөнхий сайд Ж.Нэругийн “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” 3 боть зохиолыг орчуулсан тухайд товчхон өгүүлэхэд: “Бямбаноров гуай М.Ганди, Ж.Нэру нарыг их хүндэлж үздэг, тэдний бүтээл туурвилыг монгол уншигчдад хүргэх талаар багагүйг хийсэн хүн дээ. Гандийн номыг орчуулах талаар их хөөцөлдөж, түүнд оролцсон төдийгүй 1980-аад оны сүүлчээр манай редакцийн төлөвлөгөөнд орсон Ж.Нэругийн “Взгляд на всемирную историю” гэдэг гурван боть номыг “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” гэсэн нэрээр орчуулсан юм. Энэ ном үнэхээр монгол уншигчдын дуртай ном болсныг харуулах ганц баримт гэвэл 1-р дэвтрийг нь бид 10000 хувь хэвлэхэд тэр дороо алга болж ховор номын жагсаалтад орсон учир дараагийн хүмүүс 2, 3-р дэвтрийг нь 15000 ширхэгээр хэвлэсэн боловч уншигчдын эрэлтийг хангаж чадаагүй”¹⁵⁰ хэмээн тухайн үед Хэвлэлийн нэгдсэн редакцид аавтай минь хамт ажиллаж байсан Соёлын Гавъяат Зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч С.Лочин дурсамждаа бичсэнийг энд дурдмаар санагдлаа. Манай нэртэй дуун хөрвүүлэгч асан, аавын минь дотны анд, Соёлын Гавъяат Зүтгэлтэн Г.Амар гуай энэ тухайд “А.Бямбаноров Энэтхэг улсын анхны ерөнхий сайд Ж.Нэругийн “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” гэдэг гурван боть бүтээлийг орчуулж гаргасан нь дорно дахины гүн ухаан, тэр их эрдэмтний ертөнцийг үзэх үзлийг монгол уншигчдад ойлгуулахад жинтэй хувь нэмэр болсон билээ.”¹⁵¹ гэж дурсан бичсэн билээ.

Энэ орчуулгыг хийснээр Ж.Нэруг ихэд хүндэтгэн үзэх болсон бөгөөд энэ тухайгаа Ж.Нэругийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм

¹⁵⁰ С.Лочин, Соёлын Гавъяат Зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор. А.Бямбаноровт зориулсан дурсамжаас нь ишлэв. 2015

¹⁵¹ “Орчуулгын хүндийг үүрэлцсэн хүмүүс: Артын Бямбаноров”, Утга зохиол сонин, 1998, 5 сар, № 10.

шинжилгээний хурал дээр хэлсэн үгэндээ тодорхой илэрхийлсэн байдаг. Тэрээр “Аугаа их Энэтхэгийн ард түмний гарамгай удирдагч Жавахарлал Неругийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний энэ хуралд оролцуулж, үг хэлэх далим олгосонд таашааж байнам....Неругийн энэ зохиолыг орчуулна гэдэг мэдлэг мөхөс надад ахадсан ажил байсныг би орчуулах явцдаа ухаарч авснаа нуух юун. Мэдэхгүй чадахгүйн зовлонг ихэд амсаж, дэлхийн түүхийн, ялангуяа дорно дахины түүхийн ном зохиолуудыг сөхөж үзэх, ном эрдэмтэй хүмүүс дээр номоо барьж очин асууж лавлах явдал бишгүй тохиолдож байлаа. Яахав тэгээд орчуулсан болоод ном гарсны дараа уулзаж учирсан хүмүүс ам сайтай байсан, ном ч дорхноо гүйгээд алга болсон....Нөхдөө, Неруг би биширсэн. Түүний олон талын өргөн их мэдлэг боловсролтойд би биширсэн....Неру өөрийгөө түүхч биш гэж бичсэн байдаг. Гэтэл түүхч биш хүн, тэр тусмаа орон шоронгийн хүнд нөхцөлд дэлхий ертөнцийн түүхийг эрт үеэс нь эхлэн эдүгээг хүртэл босгоно гэдэг тэр хүний өргөн их мэдлэгтэйн шалгуур яах аргагүй мөн. Түүхийг, түүхэн үйл явдлыг тийнхүү харуулахдаа энгүүн чөлөөтэй мөртлөө элдэв ангийн, намын үзэл санаа, улс төрийн бодлогод нийцүүлэх гэсэн явцуурхалд авталгүй, өөрөөр хэлбэл, түүхийг гуйвуулж алагчлалгүй, үнэнч шударгыг баримтлан яг л байснаар нь бичсэн нь надад ойлгогдсон. Энэ чанар бол ялангуяа шинэ сэтгэлгээ ил тод байдал дэлгэрч, жишээ нь манайд нам, улсын түүхийг гуйвуулж байсан, түүнийг одоо засан сэргээх ажил хийгдэж байгаа үед манай түүхчдэд сургамжтай жишээ мөн гэж бодогдном.”¹⁵² гэж хэлж байжээ.

3. Орчуулгын дараагийн нэг төрөл болох уран зохиолын орчуулга

ЗХУ-ын “Прогресс” хэвлэлийн газар томилогдон ажиллах хугацаандаа энэ чиглэлийн орчуулга руу орсон гэж үзэж болно. 1975 онд мөн тухайн үеийн МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр Прогресс хэвлэлийн газар 3 жил ажиллахаар томилогдоод амжилттай ажилласан учир ахин 2 жилээр хугацаа нь сунгагдаж 1980 он хүртэл буюу нийт 5 жил ажилласан билээ. Энэ тухайд орчуулагч, эрдэмтэн С.Лочин: “Бямбаноров гуай хэдэн жил Москвад “Прогресс” хэвлэлийн газар ажилласан билээ. Уг хэвлэлийн газар гучаад оны үеэс монгол хэлээр олон ном хэвлэдэг байсан уламжлалаа сэргээж, монгол хэлээр ном хэвлэдэг болсон юм. Тэнд уран зохиолоос эхлээд нийгэм улс төр, эдийн засаг, байгалийн ухааны салбар салбарын номыг орчуулан хэвлэх болсон тул аль ч салбарын номыг орчуулах, редакторлах чадвартай хүн редакцид Бямбаноров гуай, Г.Амар хоёроос өөр хүн бараг байгаагүй болохоор Бямбаноров гуай анхлан “Прогресс”-д ажилласан юм. Сүүлд нь манай алдарт орчуулагч Гүрбазарын Амар ч бас л тэнд очиж ажилласан даа. Ингэж л Хэвлэлийн редакци “их хутгаа сугалж” тэр хоёр аугаа хүнийг эх орныхоо элч болгон явуулж байлаа.”¹⁵³

¹⁵² Орчуулагчийн хувийн архиваас.

¹⁵³ С.Лочин, Соёлын Гавьяат Зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор. А.Бямбаноровт зориулсан дурсамжаас нь ишлэв. 2015

Тэнд ажиллаж байхдаа монгол уншигчдад зориулж оросоос монгол руу ном орчуулахын зэрэгцээ, мөн Монголоо сурталчлах таниулах үүргийн хувиар монгол ном зохиолыг орос хэл рүү хөрвүүлэн хэвлэдэг байв. Энэ нь орчуулагчийн маань хувьд шинэ сорилт байсан гэж үзэж болно. Учир нь урьд нь зөвхөн оросоос монгол хэл рүү орчуулга хийдэг байсан юм. Энд ажиллаж байхдаа улс төр, нийгэм эдийн засгийн орчуулгынхаа зэрэгцээ уран зохиол, хүүхдийн үлгэр зэргийг орчуулж эхэлсэн байна. Жишээ болгон дурдвал: Нисэх онгоц зохион бүтээх ажлынхаа замналыг дурсан бичсэн социалист хөдөлмөрийн баатар А.С.Яковлевын “Амьд явсны хэрэг”, В.Маяковскийн “Энх цагийн тулалдаан”, “Абверийн тагнуулч”, “Зөвлөлт аж төрөх ёс”, нэрт жанжин З.А.Золототрубовын “Гавьяат замнал” тууж, нэрт зохиолч Мария Трилятаевагийн “В.И.Лениний амьдрал”, Р.Гамзатовын “Миний Дагестан”, “Учиртай төрсөн хорвоо”, А.Лесновын “Нарны салхи”, И.Коваленкогийн “Азид энх тайван, хамтын аюулгүй байдал тогтоохын төлөө ЗХУ-ын хийж буй тэмцэл”, “Маша и медведь”, “Колосок” гэх мэт олон арван ном орчуулж редакторложээ.

Хүүхдийн зохиол, танин мэдэхүй: Орчуулагч А.Бямбаноров гавьяаныхаа амралтанд гарсан хойноо ч уран бүтээлээ туурвисан хэвээрээ, хэдийгээр хүнд өвчинд нэрвэгдсэн ч таниулан мэдэхүй, түүх соёлын сэдэвтэй олон өгүүлэл, хүүхдэд зориулсан үлгэр, тууж орчуулж, заримыг “Хөх толбо” зэрэг сонинд, заримыг тусгай ном болгон хэвлүүлж байлаа. “Хүүхэд багачуудын унших, үзэх зүйлд онцгой анхаарч байсныг дурдууштай юм. “Франц ардын шилмэл үлгэрүүд” гэдэг 2 боть ном, “Ах дүү Гриммийн үлгэр”-ийг тусгай ном болгон хэвлүүлээд алдарт Хоже Насерединый нэлээд үлгэрээс орчуулж “Сайн байна уу” сонинд нийтлүүлэхээр харилцан тохирсноо ярьж байж билээ. Түүнчлэн Петров зохиогчтой “Цасны хүн” номыг орчуулаад Цэргийн хэвлэх үйлдвэрт өгөөд хэвлэгдэн гарахыг нь хүлээж чадалгүй бие барсан билээ.”¹⁵⁴

Орчуулгын онцлогийг нь авч үзвэл зөвхөн толь бичигтэй ноцолдоод зогсохгүй байнгын эрэл хайгуул хийдэг, мэргэжлийн хүмүүс, зохиолч, эрдэмтэдтэй их зөвлөлдөж мэтгэлцдэг, хүмүүсийг их бага гэж голохгүй хүүхэд бидэнтэй ч ярьж санал асуудаг байж билээ. Өөрөөр хэлбэл, орчуулахын тулд судалгаа их хийдэг, орчуулснаа эргэж нарийн нягталдаг, өөртөө шүүмжлэлтэй ханддаг байсан нь өнөө бидэнд үлгэр дууриалалтай зүйл. МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институтээс В.И.Лениний ботиудыг цувралаар орчуулан, хянаж нийтлэх үеэр өөрийн ажлын тайланд: “Ажлын чанарын хувьд хэлэхэд хэцүү байна. Орчуулга гэдэг хэцүү, нарийн ажил, тэгэх тусмаа Лениний зохиол орчуулж, редакторлох ажил хариуцлагатай болохыг ойлгож аль болох сайн хийхийн төлөө чармайж ирэв. Энэ талаар хамт ажилладаг нөхөд тусалж байна. Гэхдээ ажил дээр бэрхшээл их тохиолдож байна. Хуучин орчуулгад засвар их орж, хөдөлмөр их шаардагдаж байна. Үзэг

¹⁵⁴ Г.Амар “Эгэл эрхмүүд” ном, “Алтан Богдыг дуулдаг Артын Бямбаноров” дурсамж өгүүлэл, УБ, 2003, 145-р тал.

хүрэхгүй өнгөрөх хуудас гэж байхгүйгээр барахгүй, зарим хуудас бүтнээрээ шахам засагдаж байна. Хуучин орчуулгын гол дутагдал нь хэл найрлага болхи, үгийг онож зөв хэрэглээгүй, нэр томъёо буруу тогтоосон, утгыг тодотгож гаргаагүй бүдүүвчилсэн, зарим талаар утгыг буруу ойлгож орчуулсан буюу найрлага муугаас утга хазайсан зэрэг байдал ажиглагдаж байна. Орчуулга муу байгаагийн гол шалтгаан нь уг ажилд хариуцлагагүй, хөнгөн хуудам хандсан, мөн уг асуудлаа ойлгоогүй байсантай холбоотой болов уу. Миний хувьд ч утгыг ойлгоход бэрх хэцүү нарийн үг хэллэг олон тохиолдож байна.”¹⁵⁵ хэмээн бичиж байсан нь тухайн үед орчуулгын ажлын чанар чансааг ихээхэн анхаарч нэн хариуцлагатай хандаж байсныг харуулах нэгээхэн жишээ юм.

Бас нэг онцлог нь зөвхөн ганц төрлөөр хязгаарлахгүй, нийгэм улс төр, эдийн засаг, соёл, танин мэдэхүй, уран зохиолын зэрэг өргөн хүрээний ном орчуулж байсан нь эрхэлж байсан ажилтай нь холбоотой байсан. Энэ тухайд дуун хөрвүүлэгч Г.Амар асан: “Бямбаноровын уран бүтээлийг одоо ажиглахад маш олон салбарын ном зохиолыг орчуулсан нь харагдана. Энэ бол талийгаачийн олон талын мэдлэг боловсролыг харуулсан сонгодог жишээ мөн гэлтэй. Жишээлбэл, Д.Карниегийн “Цуврал лекц” бол уншихад ойлгомжтой хөнгөн зүйл мэт боловч нарийн утга санааг нь гаргаж буулгахад тийм ч амар зүйл биш. Гэвч манай Бямбаноров тун чадамгай сайн орчуулж, гурван дэвтэр болгон хэвлүүлсэн бөгөөд тэдгээрийг нь хэвлэлийн “Сүхбаатар” компани нийлүүлж нэгэн дэвтэр болгон хэвлэсэн харагдана билээ.”¹⁵⁶ хэмээн дурсамждаа бичжээ.

Орчуулагчийн ур чадварын тухайд: орчуулагч хүнд тавигддаг гурван шаардлагыг хангасан орчуулагч байлаа. Орчуулга хийж буй хэл буюу бичгийн орос хэлийг сайн эзэмшсэний зэрэгцээ төрөлх хэлээ гаргууд мэддэг, найруулан бичих чадвар сайтай, үгийн утгыг эх текстэнд тааруулан олж сонгох авъяас билэгтэй, эх текстийн утгын гүнд орж ойлгох торгон мэдрэмжтэй хүн байлаа. Орчуулга хийхэд эх монгол хэлний мэдлэг хамгийн чухал болохыг байнга давтдаг байж билээ. “Бямбаноров орчуулга хийхдээ солгой гараар нилээд түвэгтэй юм шиг бичдэг байснаа бүр тавь гарсан хойноо маш хурднаар шууд машинддаг болсон нь бахархууштай санагддаг. Нас сүүдэр дал гарсан ч орчуулгаа хийсээр, машинаа тачигнуулсаар байсан нь ерөөсөө уран бүтээлч хүмүүсийн хувь тавилан гэж хэлж ч болно. Бямбаноров маань 73-ныхаа жил дээр бие барсан нь нэг талаар өвгөн насан болчихсон мэт боловч чухам үнэндээ ёстой л “уран бүтээлийнхээ ид цэцэглэлтийн үед” ертөнцийн мөнх бусыг үзүүлснийг түүний хэвлүүлж амжаагүй хэд хэдэн ном, хийж байгаад дутуу

¹⁵⁵ Орчуулгын тасгийн ахлах редактор А.Бямбаноровын 1984 оны 2-р хагас жилийн ажлын тайлан, хувийн архив.

¹⁵⁶ Г.Амар “Эгэл эрхмүүд” ном, “Алтан Богдыг дуулдаг Артын Бямбаноров” дурсамж өгүүлэл, УБ, 2003, 145-р тал.

орхисон бүтээл нь харуулж байна. Авъяас тэтгэвэрт гардаггүй гэдэг аргагүй үнэн ажээ”¹⁵⁷ хэмээн Г.Амар асан дурсжээ.

Бусад үйл ажиллагаа: Орчуулгын үндсэн ажлынхаа хажуугаар олон төрлийн ажил хийдэг нийгмийн идэвхтэй, удирдан зохион байгуулах, хүнтэй ажиллах чадвартай, биеийн тамир спорт их сонирхдог хүн байлаа.

Бага залуугаасаа дунд сургуулийн хичээлийн эрхлэгч, захирал зэрэг ажлыг хийж эхлээд хожим нь намын шийдвэр даалгавраар намын хорооны даргын үүрэгт ажил мөн олон жил хашсан. 1960-аад оноос Хэвлэлийн Нэгдсэн Редакцийн улс төрийн номын хэлтсийг олон жил удирдан ажиллаж байгаад хожим нь эдийн засгийн редакцийг өөрөө санаачлан байгуулж удирдан ажиллаж байжээ. “Нийгэм улс төрийн номыг хөл дээр нь босгосныхоо дараа эдийн засгийн редакцийг санаачлан, хөөцөлдөж байж байгуулаад хөл дээр нь босгосон нь манайд эдийн засгийн шинэчлэл явуулах шаардлагатайг ойлгож байсных байх гэж боддог. Тус редакци эдийн засгийн шинэчлэлийн талаар олон ном орчуулж, бас манайхны гайгүй гэсэн эрдэмтэн мэргэдээр энэ чиглэлээр ном бичүүлж гаргаж байсныг нь би сайн санаж байна. Ялангуяа эдийн засгийн том толь гаргасан нь өнөөдөр ч зарим үед хэрэг болж л байгаа гэж боддог. Плехановын эдийн засгийн зарим ном зохиолыг орчуулж гаргасан санагдана. Энэ бүхэн бол тухайн цагтаа зарим талаар эрсдэлтэй алхам байсан ч гэлээ, Бямбаноров гуай ухаантай хүн учир, хэн яаж мушгивал өөдөөс нь хэрхэн хариулж, хийсэн ажлаа хамгаалахаа урьдаас бодчихсон байдаг байх гэж санагддаг.”¹⁵⁸ хэмээн хамтран зүтгэгч С.Лочин дурсаж байна.

Тухайн цаг үеийн боловсрол мэдлэгтэй сэхээтнүүдийн нэгэн адил цаг үеийн асуудлаар улс төрийн сонсгол болон лекц яриа хийх ажилд их дайчлагддаг байсныг тод санаж байна. Москва хотноо “Прогресс” хэвлэлийн газар ажиллаж байхдаа ч Монголын Элчин сайдын яамны ажилтнууд болон оюутнуудад улс төрийн сонсгол, лекц, яриа хийх, тэндхийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улсынхаа ном хэвлэлийн ажлыг сурталчлах, олон улсын хэвлэлийн ажилтны хурал, зөвлөгөөн, олон улсын номын үзэсгэлэн худалдаанд оролцох зэргээр хүчин зүтгэж байв. Мөнхүү онол улс төр болон улс орны хөгжил, цаг үеийн асуудлаар олон нийтэд зориулж өгүүлэл, нийтлэл бичин сонин сэтгүүлд хэвлүүлдэг идэвхтэн бичигч, нийтлэлч байлаа.

Дээр өгүүлсэнчлэн биеийн тамир спорт их сонирхож, шатар сайн тоглодог байсан юм. Албан ёсны цол зэрэггүй болохоос мастерын дайтай шатарчин байсан гэж орчуулагч Г.Амар аавын тухай дурсамждаа бичсэн байсан. Тэрээр: “...Намайг оюутан байхад Улаанбаатарт болсон олон улсын шатрын тэмцээний үеэр олон улсын мастер М.Юдович Их сургууль дээр ирж тоглоход түүнийг хожсон цөөхөн хүний нэг Бямбаноров байлаа. Түүнээс хойш ч дэлхийн аварга

¹⁵⁷ Мөн тэнд, 148-р тал.

¹⁵⁸ С.Лочин. Бямбаноровын талаарх дурсамжаас

болон олон улсын мастер хэд хэдэн хүнтэй тоглоход би дэргэд нь байж байлаа. Хамгийн гол нь Бямбаноров тэр олон мундагуудыг хожиж байлаа. Бямбаноров шатраас гадна шагай, даалуу, хэзрийн аль алинаар сайн тоглодог, гар бөмбөг, бокс, бөх, тэшүүр ер спортын ямар л бол ямар төрлийг сонирхож, бид бүгдтэй хамт явж үздэг байсансан. Мөн бооцоо мөрий тавьж, бөөн хөгжилдөөн болж, хөдөө гадаа самар жимсэнд цуг явахад наргиантай наадамтай байдагсан”¹⁵⁹ хэмээн дурсан бичжээ.

Орчуулагч А.Бямбаноров хүний хувьд сэргэлэн цовоо, эгэл даруу, шударга зарчимч, үнэн үгийг ил тод шууд хэлдэг, нөхөрсөг нийтэч зантай, гэр бүл үр хүүхэд, ах дүү найз нөхөд, хамтран зүтгэгч наргаа түшигтэй, туйлын тусархаг хүн байсан юм. Орчуулагч эрдэмтэн, түүний олон жилийн хамтран зүтгэгч С.Лочин гуай: “Бямбаноров гуай үнэхээр уул шиг түшиг тулгууртай, нөөлөг нөмөртэй, олон талын мэдлэгтэй, уншсан, үзсэн, туулсан ихтэй, орчуулсан, хийсэн ажил арвинтай, амьдралын баялаг туршлагатай, цэцэн цэлмэг үг хэллэгтэй, сэргэлэн соргог оюун ухаантай, үргэлж үнэний талыг барьдаг, хэлэх гэсэн үгээ хэнбугайн өөдөөс ч инээж байгаад хэлчихдэг, хар буруу санаагүй, хайлган зөөлөн сэтгэлтэй, гал дөл шиг дүрэлзсэн, эрмэлзлэл, тэмүүлэлтэй гайхамшигтай хүн байсан юм даа.”¹⁶⁰ хэмээн дурсаж билээ. Нэрт дуун хөрвүүлэгч асан, дотны анд нь явсан Г.Амар энэ тухайд: “Бямбаноровын бас нэг онцлог нь насны илүүгээр их зан гаргаж хий цээж гаргадаг хүмүүсээс эрс ондоо, залуу хүмүүстэй ихэд үерхдэг, залуу хүнийг дэмждэг, ер нь дэвшилттэй шинэ юмыг амархан тусгаж аваад тэр бодолдоо бат зогсдог байв.” “Миний хувьд Бямбаноровтой үг хэлээ маш амархан ололцож, бусдыг үгээр идэх, цаашлуулах талд ам хэл нэгддэг байв. Хэвлэлийн газрын “өндөр хар, өндөр шар хоёр хэцүү” гэгддэг байв.”¹⁶¹ гэж дурсан бичсэн байна.

Эцэст нь дүгнэхэд, орчуулагч А.Бямбаноров нь орчуулгын болоод хянан засварлаж нийтлүүлсэн зохиол бүтээлээрээ 20-р зууны хүлээн зөвшөөрөгдсөн орчуулагч, мэдлэг боловсролын хувьд тэргүүний сэхээтнүүдийн нэгэн төлөөлөл байжээ хэмээн үзэж байна. Тэрээр олон салбар чиглэлийн ном зохиолыг чадварлаг орчуулж олны хүртээл болгосон нь өнөө ч үнэ цэнээ алдаагүйг дахин хэвлэгдэж буй орчуулгын бүтээл нь харуулна.

Ашигласан материал:

1. Г.Амар.Эгэл эрхмүүд, УБ, 2003
2. Г.Амар.Миний тавилан, дуртгал, УБ, 2009.
3. А.Бямбаноровын хувийн архив
4. Галуутайн хүүхдүүд, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын 50 жилийн ойд зориулсан ном, эрхэлсэн Ч.Энзэндагва, УБ, 2009.
5. С.Лочин, Соёлын Гавъяат Зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор. А.Бямбаноровт зориулсан дурсамж (хэвлэгдээгүй)

¹⁵⁹ Г.Амар. Эгэл эрхмүүд, 146-р тал.

¹⁶⁰ С.Лочин...

¹⁶¹ Г.Амар. “Миний тавилан” дуртгал, УБ, 2009, 185-р тал.

6. Улаан-Од сонин, 1989-10-25, № 85.
7. Утга зохиол сонин, 1998 – 5 сар, № 10.



**Зүүн гараас хоёр дахь нь А.Бямбаноров, дорны их яруу найрагч
Б.Явуухулан болон хэвлэлийн ажилтнуудын хамт**



**Зүүн гараас хоёр дахь нь А.Бямбаноров, олон улсын
хэвлэлийн ажилтны хуралдаан дээр**